



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД ЛУВСАННАМСРАЙН
ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 28-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.09.25 № 19

Төсвийн зөрчлийн шалтгаан нөхцөл,
хяналт, хариуцлагын механизмын хэрэгжилт,
цаашид авах арга хэмжээний талаар

Улсын Их Хурал Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн Аудитын тайланг ээлжит бус чуулганаараа хэлэлцэн баталсан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл тус тайлан, гүйцэтгэлд өгсөн дүгнэлтдээ "Төсвийн захирагчид /ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд/ жилийн эцсийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлээ тайлагнадаггүй, зөрүүтэй тайлагнасан, тайланд нэгтгүүлдэггүй, төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлдэггүй, цалин хөлс, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу тооцож олгодог, батлагдсан төсвийн хөрөнгийг хэтрүүлсэн, зориулалтын бус зүйлд үр ашиггүй зарцуулсан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч зарлагын гүйлгээ хийдэг, хууль давсан дүрэм журам гаргадаг, төсвийн зарлагын эх үүсвэрийн дутагдлыг төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлдэг, Сангийн яам, Монгол банкны зөвшөөрөлгүйгээр арилжааны банкнуудад данс нээх, Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд төсвийн хөрөнгийг байршуулдаг зэрэг асуудлууд нь төсвийн сахилга бат, хариуцлага суларч, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зарчмууд алдагдаж байгааг Үндэсний аудитын газрын дүгнэлт харуулж байна" гэдгийг онцолжээ.

Дээрх байдлаар төсвийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдлууд Үндэсний аудитын газрын тайланд олноор тусгагдсан нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн суурь зарчмуудыг төрийн байгууллага, албан тушаалтнууд баримтлахгүй, татвар төлөгчдийн мөнгө, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг зүй зохистой удирдахгүй байгаагийн илрэл буюу олон нийтийн төрд итгэх итгэлийг алдуулж буй ноцтой асуудал гэж үзэж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн, батлах 2025 оны нэгдсэн төсвийн зарлага тодогоор 35.8 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн нь 2024 оны төсвийн тодотголоос хойш зарлага дахин 15 хувиар нэмэгджээ. Төсвийн зардал нэмэгдэхийн хэрээр зөрчил дутагдал төдий чинээ ихсэх нь өмнөх төсвийн гүйцэтгэлийн дүгнэлтээс илэрхий байна.

Иймд хууль зөрчиж буй шалтгаан нөхцөл, асуудлыг шийдвэрлэж, учирсан хохирлыг төлүүлж буй байдал, гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргасан албан

20240040

тушаалтнуудад хариуцлага тооцож буй байдлын талаар дэлгэрэнгүй; мөн цаашид төсвийн хууль тогтоомжийг чанд сахин биелүүлэх, төсвийн хяналт шалгалт болон хариуцлагын тогтолцоог сайжруулах улс төрийн хүсэл, эрмэлзэл байгаа эсэх, мөн байгаа тохиолдолд хэрхэн хийхээр төлөвлөж буй талаар мэдээлэл авах зорилгоор Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.3, 37.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах зөрчлийн хүрээнд дор дурдсан асуулгыг тавьж байна. Үүнд:

Зөрчил:

1.Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1,1 их наяд төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;

2. Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 256.3 тэрбум төгрөг /УУХҮС 234.6 тэрбум төгрөг, Сангийн сайд 12 тэрбум төгрөг, БХБС 3.1 тэрбум төгрөг, БШУС 1.9 тэрбум төгрөг, ХНХС 1.3 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.7 тэрбум төгрөг, ХЗДХС 0.6 тэрбум төгрөг, ОНБТСҮХ 0.3 тэрбум төгрөг, ЭМС 0.2 тэрбум төгрөг, МУЕП 0.2 тэрбум төгрөг, ЦХХХС 0.2 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.1 тэрбум төгрөг, ЗТХС 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/;

3.Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 1.3 тэрбум төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн /Нийслэл 0.6 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 0.4 тэрбум төгрөг, Төв аймаг 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;

4.Бараа материалыг хэрэгцээнээс илүү бэлтгэсэн, хадгалалтын хугацаа хэтэрсэн, ашиглалтгүй, эргэлт удааширсан 73.8 тэрбум төгрөг /УУХҮС 65.9 тэрбум төгрөг, ЭХС 4.4 тэрбум төгрөг, БХБС 1.8 тэрбум төгрөг, ЭМС 1.3 тэрбум төгрөг, ХНХС 0.1 тэрбум төгрөг, ХХААХҮС 0.1 тэрбум төгрөг/;

5.Баталсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан 13.9 тэрбум төгрөг /БШУС 4.9 тэрбум төгрөг, МУЕП 3 тэрбум төгрөг, ХНХС 2.3 тэрбум төгрөг, УУХҮС 1.1 тэрбум төгрөг, Соёлын сайд 0.9 тэрбум төгрөг, Сангийн сайд 0.5 тэрбум төгрөг, ЭМС 0.5 тэрбум төгрөг, ЭХС 0.4 тэрбум төгрөг, ШСХ 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;

6.Баталсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй 1.9 тэрбум төгрөгийг зарцуулсан /Завхан аймаг 0.8 тэрбум төгрөг, Булган аймаг 0.4 тэрбум төгрөг, Ховд аймаг 0.3 тэрбум төгрөг, Өмнөговь аймаг 0.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг /;

7.Нийт 9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан /ЭМС 3.2 тэрбум төгрөг, ШЕЗ 3 тэрбум төгрөг, ОНБТСҮХ 2.7 тэрбум төгрөг, ГХС 0.1 тэрбум төгрөг/.

Асуулга:

1.Зөрчил 1-т заасан авлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, барагдуулж буй үйл явц,төлөвлөгөө

20240040

2. Зөрчил 2,3 -т заасан хүлээн зөвшөөрч бүртгэсэн ажил гүйлгээ, зөрчлийн шалтгаан тус бүрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тайланг Төсвийн Ерөнхийлөн захирагч тус бүрээр;

2.Зөрчил 4-т заасан бараа материалын нэр төрөл, зөрчлийн шалтгаан тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, тайланг Төсвийн Ерөнхийлөн захирагч тус бүрээр, мөн эдгээр бараа материалыг хэрхсэн болон цаашид хэрхэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

3.Зөрчил 5, 6-д заасан дүн бүхий баталсан төсвийг хэрхэн хэтрүүлсэн, зориулалт бусаар юунд, хэрхэн үр ашиггүй зарцуулсан тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тайланг Төсвийн Ерөнхийлөн захирагч тус бүрээр, мөн хохирлыг хэн, хэрхэн барагдуулах тухай мэдээлэл;

4.Зөрчил 7-д заасан мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй шалтгаан, нөхцөлийн талаарх мэдээлэл;

5.Зөрчил тус бүрээр хуулийн дагуу хүлээлгэх хариуцлага нь юу болох тухай болон холбогдох албан тушаалтан хариуцлага хүлээсэн эсэх, мөн хохирлыг шийдэх арга зам, хэлбэр юу болох тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

Дээрх зөрчлүүд нийт зөрчлүүдийн өчүүхэн хэсэг хэдий ч ноцтой тул төсвийн хяналт, хариуцлагын механизмтэй холбоотойгоор дараах асуулгыг тавьж байна.

6.Асуулгын эхэнд дурдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах чиг үүрэг бүхий хүний хувьд Ерөнхий сайд Та хүлээн зөвшөөрч байгаа эсэх; зөвшөөрч байгаа бол дээрх зөрчлүүдийг таслан зогсоох чиглэлд авахаар төлөвлөж буй арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

7.Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бол тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж заасны дагуу хариуцлага тооцсон албан тушаалтнуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

8. Засгийн газрын төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт болон тогтолцооны талаарх санал, дүгнэлт;

9.Санхүүгийн зөрчил гаргасан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч, албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг механизмын хэрэгжилт болон тогтолцооны талаарх санал, дүгнэлт;

Энэ асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАЯРМАА

20240040